

БАТЛАВ
САЛБАРЫН ДАРГА  Т.МӨНХБАЯР

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2023 оны 05 дугаар сарын 16-ний өдөр	№2023/16	Мандалговь хот
1.Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд болон байгууллага	<i>Дундговь аймаг, Дэрэн сум, Эрүүл мэндийн төв</i>	
2.Хэрэглэгчийн хаяг:	<i>Дундговь аймаг, Дэрэн сум, 1-р баг, Шандын 6-602 тоот</i>	
3. Хэрэглэгчийн байршил, зэрэглэл:	<i>Дундговь аймаг, Дэрэн сум, 1-р баг, Шандын 6-602 тоот II зэрэглэл</i>	
4. Ажил үйлчилгээний зориулалт	<i>Эрүүл мэндийн төв, эмнэлэг</i>	
5. Техникийн нөхцөл олгох үндэслэл:	<i>2023 оны 05-р сарын 04-ны өдрийн хүсэлт өргөдөл</i>	
6. Суурилагдсан чадал:	<i>Нийт 15 кВт</i>	
7. Холбогдох цэг:	<i>7.1 АТП-36 дэд станцын 0.4кВ фидер №1-ын 2*АВВГ-/3*16+1*10/-аас багагүй хөндлөн огтлол бүхий хос кабель шугамаар тэжээл авах 7.2 Кабель шугамын 0.4кВ хүчдэлийн гадна байршуулах зориулалттай, 60*80см хэмжээтэй төмөр шитийг тулгуурт тусгай тоноглолоор бэхэлж суурилуулах, шить нь цэнэг шөвхөгчтэй ба газардуулсан байх 7.3 Кабель шугамыг газраар 0.7м-ээс багагүй гүнд суурилуулж, үзүүрүүдэд төгсгөөч болон орчин үеийн шинэ технологийн муфть хийж холбох</i>	
8.Тоолуур хэмжих хэрэгсэл:	<i>8.1. Монгол улсын Стандарт хэмжилзүйн газрын загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан гэрчилгээтэй БЗӨБЦТС ТӨХК-д ашиглагдаж буй өндөр нарийвчлалтай IEC 6202-11, IEC 62053-22, IEC 62053-24 стандартын шаардлага хангасан мэдээллийг бүрэн дамжуулж интеграци хийх боломжтой программчлагдсан, 0.5S нарийвчлалтай олон үйлдэлт, 3 фазын 100А-ын ухаалаг тоолуурыг эзэмшлийн заагт байршуулна</i>	

9. Тусгай заалтууд:

- 9.1** Шинээр баригдах объектын цахилгаан хангамжийн ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн техникийн нөхцөл олгогчоор хянуулна.
- 9.2** Шинээр баригдах ЦДКШ, байршлын зураг, трассын схемийг Дундговь ЦТС салбарын инженер техникийн ажилтантай хамтран гаргана.
- 9.3** 0.4кВ-ын ерөнхий шитний газардуулгын эсэргүүцлийг "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.36-д заагдсаны дагуу 4 Ом-оос ихгүй байхаар газардуулсан байна.

9.4 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурвас, газрын зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авна.

9.5 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн түвшингийн $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.

9.6 Цахилгааны оруулга, гаргалгын кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.7 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт, хэмжилтийг Дундговь ЦТС салбараар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт, "БЗӨБЦТС" ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу цахилгаан түгээх сүлжээнд холбогдоно.

10.2 Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар "БЗӨБЦТС ТӨХК"-ийн Дундговь ЦТС салбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.3 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

10.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.5 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.6 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.7 Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:	ТҮАХМЕ ИНЖЕНЕР		Г.МЯГМАРСҮРЭН
ГИШҮҮД:	ХҮАХ МЕНЕЖЕР		Э.ТҮМЭН-ӨЛЗИЙ
	ЭЭЛЖИЙН АХЛАХ ИНЖЕНЕР		Т.ДЭВЭГДЭЛГЭР
	БОРЛУУЛАЛТЫН ИНЖЕНЕР		Н.УРАНТӨГС
	ЗАСВАРЫН МАСТЕР		Э.ЭНХ-АМГАЛАН